

БАТЛАВ.  
НИЙСЛЭЛИЙН ЭРХУЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГА ~~П.ЭРХЭМБУЛГАН~~

9023070010  
90774766 БТ22555

**“Эрүүл сургууль”-ийн цогц шалгуур үзүүлэлт боловсруулж,  
ерөнхий боловсролын сургуулиудад үнэлгээ  
хийх ажлын даалгавар**

**Зорилго**

Хүүхдүүд эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох, өсөж торних нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн хууль эрх зүйн орчныг сайжруулах хэрэгцээг тодорхойлох зорилгоор ерөнхий боловсролын сургуулиудад үнэлгээ хийх

**Хийгдэх ажил**

1. Хүүхдийн эрүүл мэндийг боловсролын байгууллагын орчинд хамгаалах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үндэсний болон олон улсын стандарт, мэргэжлийн удирдамжуудад судалгаа хийж, “Эрүүл сургууль” шалгуур үзүүлэлтийг боловсруулахад ашиглах лавлагаа үзүүлэлтүүдийг тодорхойлох;
2. Сургуулийн орчинд хүүхдийн эрүүл мэндэд нөлөөлдөг орчны, нийгмийн хүчин зүйлс, эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ, шим тэжээлтэй хоол хүns, идэвхтэй дасгал хөдөлгөөн, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих хамт олон болон гэр бүлийн оролцоо зэрэг үзүүлэлтийг хамарсан “Эрүүл сургуулийн цогц шалгуур үзүүлэлт”-ийг боловсруулах;
3. Эрүүл сургуулийн цогц шалгуур үзүүлэлтийг нийгмийн эрүүл мэнд, боловсролын салбарын мэргэжилтний төлөөллөөр хэлэлцүүлэн санал, зөвлөмжийг тусгаж эцэслэх;
4. Сонгосон ерөнхий боловсролын сургуулиудад боловсруулсан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийж, сургуулийн орчинд хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулахад зөвлөмж боловсруулах.

**Гүйцэтгэгчид тавигдах байгууллагад тавигдах шаардлага**

1. Нийгмийн эрүүл мэнд, эрүүл ахуйн чиглэлээр судалгааны үйл ажиллагаа явуулдаг байгууллага, мэргэжлийн холбоо
2. Дараах чиглэлээр төрөлжсөн доктор, магистрын зэрэгтэй нийгмийн эрүүл мэндийн судлаачдаас бүрдсэн багтай
  - Хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуй – 1-ээс доошгүй
  - Орчны эрүүл мэнд – 1-ээс доошгүй
  - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй – 1-ээс доошгүй

3. Хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх орчны хүчин зүйлсийн талаар судалгааны хийж байсан туршлагатай
4. Үйл ажиллагаа тасралтгүй 5 жил явуулсан байх

Хугацаа: 3 сар

Хүлээгдэх үр дүн:


- Ерөнхий боловсролын сургуулийг үнэлэхэд зориулагдсан "Эрүүл сургууль үнэлгээний шалгуур үзүүлэлт"
- Эрүүл сургууль үнэлгээний шалгуур үзүүлэлтийг ашиглан ерөнхий боловсролын сургуулиудад хийсэн үнэлгээний тайлан

Хянасан:  
ЭМДХБӨХ-ийн дарга



Д.Цэнд-Аюуш

Боловсруулсан:  
ЭМДХБӨХ-ийн ахлах мэргэжилтэн



Ж.Паламжав